



# ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

## Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

САГ-ын дарга: С.Энхзаяа  
Утас: 261663

Аудитын менежер:  
С.Оюунгэрэл  
Утас: 260512

Аудитор: И.Туяа  
Утас: 261885

Монгол Улсын Үндэсний аудитын газар

Монгол Улс  
Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу  
Засгийн газрын IY байр

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Оршил  
Санхүүгийн дотоод хяналт  
Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд  
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт  
Аудитын санал дүгнэлт

**Хавсралт 1:** Аудитын гэрчилгээ

**Хавсралт 2:** Менежментийн захидал

**Хавсралт 3:** Аудит хийгдсэн санхүүгийн  
нэгтгэсэн тайлан

**Хавсралт 4:** Жилийн төсвийн  
гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

## **Оршил**

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитыг дуусгавар болгосон тухай энэхүү тайланг танилцуулж байна. Менежментийн захидалд төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаарх зөвлөмжийг тусгасан болно.

УИХ-аар 2013 оны төсөвт зардал 402,516.8 сая төгрөгөөр анх батлагдсан ба тодотгосон төсвөөр 369,096.3 сая төгрөг буюу 33,420.5 сая төгрөгөөр буурч батлагдсан, үүнээс нийт төсвийн гүйцэтгэл 359,020.7 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт төсөвт зардлын 75.2 хувь буюу 269,857.8 сая төгрөгийг НДСангийн татаас, 4.2 хувь буюу 15,264.6 сая төгрөгийг цалин хөлс, НДШ, 8.7 хувь буюу 31,096.5 сая төгрөгийг алдарт эхийн одонгийн болон өндөр настан ахмад дайчдад олгосон тэтгэмж, 6.4 хувь буюу 23,062.6 сая төгрөгийг хотын нийтийн тээврийн татаас, 5.5 хувь буюу 19,739.2 сая төгрөгийг бараа, үйлчилгээний зардлууд тус тус эзэлж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчын багцад хамрагддаг 22 салбар, нэгжүүдээс 20 нь аудитад хамрагдаж, Монголын Ахмадын холбооны гүйцэтгэх хороо, Хүүхэд асран хүмүүжүүлэх төв аудитад хамрагдаагүй ба нийт төсөвт зардлын 83.0 хувийг Үндэсний аудитын газар, 14.3 хувийг Аймаг, нийслэлийн аудитын газар, 2.7 хувийг Гэрээт аудитын компаниуд тус тус санхүүгийн тайланд аудит хийсэн байна.

Аудитад хамрагдсан 20 салбар, нэгжүүд “Зөрчилгүй” санал, дүгнэлттэй байна.

### **Санхүүгийн дотоод хяналт**

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Ийнхүү дахин хянахдаа Төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаарх өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

Аудитын явцад дотоод хяналтыг үнэлэхэд: ТЕЗ-ын харьяа аж ахуйн нэгж, байгууллагуудын хэмжээнд санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомжийг зөрчиж орлого, санхүүжилтийн хэрэгцээгээ бодитой тодорхойлоогүй байх, батлагдсан төсөвт зардлыг хэтрүүлэх, бодитой бус их хэмжээний хэмнэлт үүсгэх, авлага, өр төлбөрийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулах, санхүүгийн тайланг буруу илэрхийлэх, данс бүртгэлд ажил гүйлгээг орхигдуулах, буруу ангилж тайлагнах зэрэг эрсдэлүүд байгаа нь дотоод аудит үр нөлөөгүйг харуулж байна. Тухайлбал: Салбар, нэгжүүдийн 2013

оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар 3,397.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч байгаа нь дотоод аудит үр нөлөөгүйг харуулж байна.

Аудитаар дээд түвшний хяналтын асуудал хөндөгдсөн бөгөөд тэдгээрийг удирдлагын анхааралд хандуулж байна.

### ***Төсвийн төлөвлөлт ба санхүүжилтийн талаар***

2013 онд төсөвт зардалд 369,096.3 сая төгрөг батлагдсанаас, 359,020.7 сая төгрөгийн зардал гаргаж, 10,075.6 сая төгрөгийн хэмнэлттэй байна.

### ***Мөнгөн хөрөнгийн талаар***

Мөнгөн хөрөнгө оны эхэнд 3,929.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант хугацаанд 368,040.8 сая төгрөгийн орлого орж, 371,669.2 сая төгрөгийн зарлага гаргасан ба оны эцэст 301.0 сая төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулсан байна.

### ***Хөрөнгө оруулалтын талаар***

2013 онд хөрөнгө оруулалтын зардалд 9,504.0 сая төгрөг батлагдсанаас, 8,722.5 сая төгрөгийг зарцуулж, үүнээс 5,900.4 сая төгрөгөөр барилга байгууламж, 1,494.5 сая төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авч, 1,327.6 сая төгрөгийн их засвар хийгдсэн ба 781.5 сая төгрөгийн хэмнэлттэй байна.

### ***Өөрийн орлогын талаар***

Өөрийн орлогын төлөвлөгөөг 2013 онд 2,179.2 сая төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 2,806.3 сая төгрөгийн орлого орсноос, 2,324.3 сая төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 482.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### ***Үндсэн хөрөнгийн талаар***

Цэвэр хөрөнгө\өмчийн өөрчлөлтийн тайланд Засгийн газрын оруулсан капитал 11,031.6 сая, хөрөнгийн дахин үнэлгээ 5,523.6 сая төгрөгөөр тус тус буурсан нь Засгийн газрын шийдвэрээр аймаг, орон нутагт 11,656.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж, Төрийн өмчийн хорооны шийдвэрээр 203.5 сая төгрөгийн барилга байгууламж акталж данснаас хассан зэрэгтэй холбоотой байна.

### ***Төсөвт зардал***

Улсын төвлөрсөн төсвөөс 366,791.3 сая төгрөг санхүүжилт олгогдохоос 360,028.2 сая төгрөгийн санхүүжилт авч, үүнээс 355,707.3 сая төгрөгийг зарцуулсан ба улсын төсөвт 4,320.9 сая төгрөгийг буцааж төвлөрүүлсэн байна.

Аудитаар илэрсэн бүх асуудлыг яамны удирдлага авч үзэж, судлан шийдвэрлэх шаардлагатай ба аудитын явцад илрүүлсэн алдааг үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрч, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаар тохиролцсон тул материаллаг алдаагүй гэж үзлээ.

## **Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд**

### ***Асуудал 1 Төвлөрсөн арга хэмжээний зардал***

Төвлөрсөн арга хэмжээний зардал 608.7 сая төгрөгөөс “Эмэгтэйчүүдийн хөгжлийн бодлого-шинэчлэл”, “Ахмад настны хөгжил, хамгааллын шинэчлэл”, “Гэр бүлийн үнэ цэнэ-хөгжил, шинэчлэл үндэсний чуулган, бусад сургалт, семинарт оролцогчдын, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх зэргийн хүлээн авалтын зардалд 95.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-д: “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэсэнтэй нийцэхгүй байна.

### ***Асуудал 2 Суудлын автомашин, түүнтэй холбоотой зардал***

ХАХНХЯ-ны харьяа салбар, нэгжүүдийн дарга нараас гадна Тэргүүн дэд болон Дэд дарга нар албан ажлын суудлын автомашин хэрэглэж байгаа ба түүнд шаардагдах шатахуун, бусад холбогдох зардалд 2013 онд 125.9 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан нь Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолын хавсралт 2.5-д: Албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан “Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагийн дарга” гэсэнтэй нийцэхгүй байна.

## **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газар аудит хийсэн ба уг аудитаар 2 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

## **Аудитын санал дүгнэлт**

Бид Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37. Факс: 32-32-86

2014.04.25 № 668

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны удирдлага нь Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангуудыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Тамгын газар-А4 бланк

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Тамгын газар-А4 бланк

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙДЫН  
ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН  
ТАЙЛАН**

**Менежментийн захидал**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**Асуудал 1**

Төвлөрсөн арга хэмжээний зардал

**Асуудал 2**

Суудлын автомашин, түүнтэй холбоотой зардал

## Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ҮАГ-ын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь ХАХНХЯ-ны салбарын хэмжээний нягтлан бодох бүртгэлийн бодлого, тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний ойлголтыг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад хамтран ажилласан ХАХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б.Отгонжаргал, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Мөнхзул болон бусад санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.



Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал

**Асуудал 1Төвлөрсөн арга хэмжээний зардал**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**ҮАГ-ын ажиглалт**

Төвлөрсөн арга хэмжээний зардлаас тухайн жилд зохион байгуулагдсан чуулган, сургалт, семинар болон хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх зэрэгт 95.0 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11-д: “төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах” гэснийг баримталж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад анхаарч ажиллах

**Эрсдэл**

Үргүй зардал гаргах, зориулалт бусаар зарцуулах \Иж бүрэн байх, Эрх ба үүрэг, Үнэлгээ\

**Үйлчлүүлэгчийн хариу**

Холбогдох албан тушаалтнуудад асуудлын бүртгэлийг танилцуулан гарын үсэг зуруулж баталгаажуулсан болно.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал

**Асуудал 2 Суудлын автомашин, түүнтэй холбоотой зардал**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**ҮАГ-ын ажиглалт**

ХАХНХЯ-ны харьяа салбар, нэгжүүдийн дарга нараас гадна Тэргүүн дэд болон Дэд дарга нар албан ажлын суудлын автомашин хэрэглэж байгаа ба түүнд шаардагдах шатахуун, бусад холбогдох зардалд 2013 онд 125.9 сая төгрөгийг зарцуулсан нь Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолын хавсралт 2.5-д заасан заалттай нийцэхгүй байна.

**Эрсдэл**

Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын мөрдөлт хангалтгүй байх \Э, Иж, Үз, Х\

**ҮАГ-ын зөвлөмж**

НХҮЕГ-ын Тэргүүн дэд дарга Ц.Алтанчимэг, Дэд дарга Б.Цэндсүрэн, Тамгын газрын дарга Д. Баасансүрэн,

ОУХ-ийн “Найрамдал” төвийн Тэргүүн дэд дарга Ц.Отгонбаяр, дэд дарга Д.Отгонбат,

СЗХ-ийн үндэсний төвийн Тэргүүн дэд дарга Д.Даникаанарын албан ажлын суудлын автомашин хэрэглэж байгаа явдлыг зогсоох,

ХТҮГ-ын дарга Тоёота Ланд круйзер 105 болон 200 маркийн өндөр үнэтэй, бензин их зарцуулдаг 2 суудлын автомашин хэрэглэж байгаа тул хот доторхи ажил, үйлчилгээнд том оврын, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг суудлын автомашин хэрэглэхийг хориглох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх

**Үйлчлүүлэгчийн хариу**

Холбогдох албан тушаалтнуудад асуудлын бүртгэлийг танилцуулан гарын үсэг зуруулж баталгаажуулсан болно.

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээр\төгрөгөөр\		
Балансын зүйл	2012 оны 12-р сарын 31	2013 оны 12-р сарын 31
<b>Хөрөнгө</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө</b>	3,929,452,501.85	302,057,535.66
<b>Авлага</b>	465,654,166.17	182,880,905.63
<b>Урьдчилгаа</b>	239,764,605.20	123,519,297.00
<b>Бараа материал</b>	1,507,988,694.34	1,350,897,843.07
<b>Эргэлтийн хөрөнгийн нийт дүн</b>	6,142,859,967.56	1,959,355,581.36
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
<b>Үндсэн хөрөнгө</b>	35,640,686,480.11	24,489,005,479.82
<b>Биет бус хөрөнгө</b>	21,683,196.80	15,728,860.30
<b>Эргэлтийн бус хөрөнгийн нийт дүн</b>	35,662,369,676.91	24,504,734,340.12
<b>Хөрөнгийн нийт дүн</b>	41,805,229,644.47	26,464,089,921.48
<b>Өр төлбөр</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
<b>Өглөг</b>	2,823,797,858.52	297,883,328.72
<b>Урьдчилж орсон орлого</b>		
<b>Бусад өглөг</b>		
<b>Богино хугацаат өр төлбөрийн нийт дүн</b>	2,823,797,858.52	297,883,328.72
<b>Цэвэр хөрөнгө</b>		
<b>Цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлт</b>		
<b>Засгийн газрын оруулсан капитал</b>	32,045,435,064.54	21,013,854,992.08
<b>Дахин үнэлгээний нөөц</b>	12,964,678,435.98	7,440,986,934.17
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(6,028,681,714.57)	(2,288,635,333.49)
<b>Өмнөх үеийн үр дүн</b>		(3,911,138,720.10)
<b>Тайлант үеийн үр дүн</b>		1,622,503,386.61
<b>Цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлтийн нийт дүн</b>	38,981,431,785.95	26,166,206,592.76
<b>Өр төлбөр, Цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлтийн нийт дүн</b>	41,805,229,644.47	26,464,089,921.48

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх	\төгрөгөөр\	
Балансын зүйл	2012 оны 12-р сарын 31	2012 оны 13-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны орлого		
Татаас санхүүжилтийн орлого	540,459,427,011.04	355,738,498,105.03
Үндсэн үйл ажиллагааны орлого	3,266,814,036.77	3,004,081,704.54
НДСангаас		164,570,226.20
Нэмэлт санхүүжилт		2,105,599,498.05
Засгийн газрын нөөц сангаас		504,000,000.00
Урьд оны хөрөнгийн санхүүжилт		2,782,863,836.00
Олон улсын байгууллагын тусламж		217,876,708.47
Бусад орлого		8,356,475,424.29
<b>Үндсэн үйл ажиллагааны орлогын нийт дүн</b>	<b>543,726,241,047.81</b>	<b>372,873,965,502.58</b>
Үндсэн үйл ажиллагааны зардал		
Цалин,хөлс болон ажиллагсдын тэтгэмж	10,069,324,444.56	15,460,754,999.65
Нийгмийн хамгааллын зардал	455,626,040,131.19	34,032,947,172.53
Бараа үйлчилгээний зардал	62,191,734,940.38	21,169,191,762.44
Элэгдэл, хорогдлын зардал	1,697,203,571.45	1,843,583,326.35
Татаас, тусламж, шилжүүлэг	11,714,874,478.25	297,874,557,709.13
<b>Үндсэн үйл ажиллагааны зарлагын нийт дүн</b>	<b>541,299,177,565.83</b>	<b>370,381,034,970.10</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>2,427,063,481.98</b>	<b>2,492,930,532.48</b>
Үндсэн бус үйл ажиллагааны орлого		<b>238,238.00</b>
Гадаад валютын ханшийн зөрүүний олз		238,238.00
Үндсэн хөрөнгө борлуулсаны олз		
Үндсэн бус үйл ажиллагааны зарлага	<b>84,761,901.39</b>	<b>870,665,383.87</b>
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз		
Үндсэн хөрөнгө борлуулсаны гарз	84,761,901.39	870,665,383.87
<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>2,342,301,580.59</b>	<b>1,622,503,386.61</b>

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх	\төгрөгөөр\	
Үзүүлэлт	2012 оны 12-р сарын 31	2013 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хүлээн авсан мөнгөн хөрөнгө:		
Татаас, санхүүжилтийн орлого	540,422,802,049.51	355,738,498,105.03
Үндсэн үйл ажиллагааны орлого	3,112,802,781.14	3,004,081,704.54
НДСангаас		164,570,226.20
Нэмэлт санхүүжилт		2,105,599,498.05
Засгийн газрын нөөц сангаас		504,000,000.00
Урьд оны хөрөнгийн санхүүжилт		2,782,863,836.00
Олон улсын байгууллагын тусламж		217,876,708.47
Бусад орлого		3,523,345,803.00
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын нийт дүн	<b>543,535,604,830.65</b>	<b>368,040,835,881.29</b>
Зарцуулсан мөнгөн хөрөнгө:		
Цалин, хөлс болон ажиллагсдын тэтгэмж	10,023,990,604.72	15,473,129,327.34
Нийгмийн хамгааллын зардал	180,620,042,103.72	33,924,769,020.33
Бараа үйлчилгээний зардал	9,219,751,152.10	11,658,922,600.59
Татаас, тусламж, шилжүүлэг	284,526,660,078.26	298,232,714,869.50
Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн хөрөнгийн нийт дүн	<b>484,390,443,938.80</b>	<b>359,289,535,817.76</b>
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	<b>59,145,160,891.85</b>	<b>8,751,300,063.53</b>
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Биет болон биет бус хөрөнгө худалдан авсан	55,215,708,390.00	12,378,695,029.72
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	<b>55,215,708,390.00</b>	<b>12,378,695,029.72</b>
Гадаад валютын арилжааны (гарз)олз		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	<b>3,929,452,501.85</b>	<b>(3,627,394,966.19)</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,929,452,501.85
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>3,929,452,501.85</b>	<b>302,057,535.66</b>

**АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

2013 оны 12-р сарын 31-ээрх				\төгрөгөөр\
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>3,929,452,501.85</b>		
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II+V)</b>	<b>369,096,272,900.00</b>	<b>359,020,665,278.90</b>	<b>10,075,607,621.10</b>	<b>97.27</b>
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (III+IV)	369,096,272,900.00	359,020,665,278.90	10,075,607,621.10	97.27
III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	359,592,272,900.00	350,298,183,989.90	9,294,088,910.10	97.42
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,125,310,700.00	13,778,247,072.67	347,063,627.33	97.54
Нийгмийн хамгааллын шимтгэл	1,540,798,500.00	1,486,437,825.67	54,360,674.33	96.47
Гэрэл цахилгаан	353,707,500.00	262,061,458.28	91,646,041.72	74.09
Түлш, халаалт	903,851,700.00	838,042,633.56	65,809,066.44	92.72
Цэвэр, бохир ус	279,651,800.00	185,787,225.24	93,864,574.76	66.44
Бичиг хэрэг	127,062,900.00	119,728,662.90	7,334,237.10	94.23
Тээвэр (шатахуун)	323,913,500.00	319,074,885.88	4,838,614.12	98.51
Шуудан холбоо	443,174,400.00	393,077,181.87	50,097,218.13	88.70
Дотоод албан томилолт	90,585,600.00	109,338,428.80	(18,752,828.80)	120.70
Гадаад томилолт /арга хэмжээ/	81,197,400.00	72,204,229.02	8,993,170.98	88.92
Ном хэвлэл авах	20,378,600.00	14,721,166.20	5,657,433.80	72.24
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	72,175,300.00	67,538,527.00	4,636,773.00	93.58
Сургалт, семинарын зардал	669,373,800.00	461,277,279.35	208,096,520.65	68.91
Багаж хэрэгсэл	363,382,000.00	231,503,751.06	131,878,248.94	63.71
Тавилга	128,332,600.00	128,269,094.98	63,505.02	99.95
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	7,475,800.00	4,008,090.00	3,467,710.00	53.61
Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс	134,888,500.00	165,475,735.35	(30,587,235.35)	122.68
Програм хангамж	2,000,000.00	1,202,400.00	797,600.00	60.12
Нормын хувцас зөөлөн эдлэл	113,228,500.00	106,988,102.00	6,240,398.00	94.49
Хоол	1,507,475,600.00	1,485,657,798.93	21,817,801.07	98.55
Эм	88,371,600.00	94,020,036.74	(5,648,436.74)	106.39
Урсгал засвар	256,366,500.00	291,901,631.28	(35,535,131.28)	113.86
Төлбөр хураамж болон бусад зардал	197,455,200.00	194,378,508.53	3,076,691.47	98.44
Гадаад зочны зардал	10,741,100.00	16,650,790.00	(5,909,690.00)	155.02
Биеийн тамирын уралдаан тэмцээн	750,000.00	1,430,000.00	(680,000.00)	190.67
Байрны түрээсийн зардал	120,138,900.00	105,137,120.15	15,001,779.85	87.51
Төвлөрсөн арга хэмжээ	1,010,316,600.00	919,228,123.30	91,088,476.70	90.98
Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт	-	(297,000.00)	297,000.00	100.00
Төвлөрсөн төсвийн хуваарилагдаагүй зардал	-	24,113,359.00	(24,113,359.00)	100.00
Шагнал, тэтгэмжийн зардал	28,302,400.00	37,579,563.00	(9,277,163.00)	132.78

Маягт хэвлэх зардал	203,825,000.00	203,169,750.00	655,250.00	99.68
Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээ	593,525,600.00	494,853,233.14	98,672,366.86	83.38
Эмнэлгийн ажилтаны мэргэжил дээшлүүлэх	7,173,500.00	4,441,925.00	2,731,575.00	61.92
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	230,572,100.00	227,480,529.38	3,091,570.62	98.66
Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	564,000,000.00	534,901,784.77	29,098,215.23	94.84
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс	42,994,000.00	31,862,060.00	11,131,940.00	74.11
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,400,000.00	136,200.00	2,263,800.00	5.68
Эд хөрөнгийн даатгал	2,988,500.00	740,136.00	2,248,364.00	24.77
Тээврийн хэрэгслийн даатгал	19,043,000.00	14,459,581.27	4,583,418.73	75.93
Галын даатгал	12,796,800.00	3,916,839.32	8,879,960.68	30.61
Харуул, хамгаалалтын хөлс	9,178,500.00	4,964,400.98	4,214,099.02	54.09
Тээврийн хэрэгслийн оношилгоо	756,000.00	905,416.00	(149,416.00)	119.76
Мэдээлэл сурталчилгааны зардал	14,151,000.00	11,197,832.14	2,953,167.86	79.13
Газрын төлбөр	300,000.00	-	300,000.00	0.00
Хог хаягдал устгах, цэвэрлэх	3,360,000.00	2,066,540.00	1,293,460.00	61.50
Хотын нийтийн тээврийн татаас	23,062,656,400.00	23,062,656,400.00	-	100.00
Бусад татаас, шилжүүлэг	274,003,761,900.00	269,857,802,782.91	4,145,959,117.09	98.49
Нөхөн олговор авагсдын шимтгэл	6,231,100.00	1,485,708.00	4,745,392.00	23.84
Өндөр настан ахмад дайчдад олгох хөнгөлөлт	2,689,100,000.00	1,963,636,197.13	725,463,802.87	73.02
Халамжийн бусад хөнгөлөлт үйлчилгээ	110,000,000.00	100,000,000.00	10,000,000.00	90.91
Ахмад дайчдад олгох нэг удаагийн тусламж	3,474,600,000.00	2,998,000,000.00	476,600,000.00	86.28
Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох тэтгэмж	30,618,800,000.00	28,098,557,954.98	2,520,242,045.02	91.77
Тэтгэвэрийн нөхөн олговор	30,942,000.00	21,775,994.00	9,166,006.00	70.38
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	170,871,000.00	154,230,556.72	16,640,443.28	90.26
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	529,678,800.00	465,379,780.00	64,299,020.00	87.86
Ээлжийн амралтаар нутаг явах унааны зардал	574,000.00	-	574,000.00	0.00
Эмчилгээний төлбөр	2,186,700.00	-	2,186,700.00	0.00
Хуульд заасан үндэслэлээр албан хаагчдад олгох	82,000,000.00	35,150,770.50	46,849,229.50	42.87
Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж	40,000,000.00	31,466,580.00	8,533,420.00	78.67
Олон улсын байгууллагын гишүүний татвар	63,400,000.00	58,161,356.90	5,238,643.10	91.74
<b>IV. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>9,504,000,000.00</b>	<b>8,722,481,289.00</b>	<b>781,518,711.00</b>	<b>91.78</b>
Барилга байгууламж	6,662,000,000.00	5,900,426,540.00	761,573,460.00	88.57
Тоног төхөөрөмж	1,500,000,000.00	1,494,478,539.00	5,521,461.00	99.63
Их засвар	1,342,000,000.00	1,327,576,210.00	14,423,790.00	98.93
<b>V. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>-</b>	
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>369,096,272,900.00</b>	<b>358,550,242,433.24</b>	<b>10,546,030,466.76</b>	<b>97.14</b>

ЭМД-аас санхүүжих	125,759,500.00	125,745,379.20	14,120.80	99.99
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,973,585,000.00	2,347,929,127.36	(374,344,127.36)	118.97
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	205,603,400.00	338,069,821.65	(132,466,421.65)	164.43
Төсвөөс санхүүжих	366,791,325,000.00	355,738,498,105.03	11,052,826,894.97	96.99
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	<b>302,057,535.69</b>	(302,057,535.69)	
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт		3,156,972,120.50	(3,156,972,120.50)	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	40.00	40.00	-	
АЖИЛЛАГСАД БҮГД	1,940.00	1,950.00	(10.00)	
Удирдах ажилтан	68.00	68.00	-	
Гүйцэтгэх ажилтан	1,196.00	1,213.00	(17.00)	
Үйлчлэх ажилтан	408.00	406.00	2.00	
Гэрээт ажилтан	268.00	263.00	5.00	